

**МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ ТӨҮГ
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 02 дугаар сарын
28-ны өдөр

дугаар 01

Улаанбаатар хот

**Удирдах зөвлөлийн
даргыг томилох тухай**

“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6 дугаар бүлгийн 6.4 дэх заалт, Авлигатай Тэмцэх Газрын 2023 оны “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай” 01/1174 дугаартай албан бичиг, Соёлын сайдын 2023 оны “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” А/26 дугаартай тушаал, “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэлийн шийдвэрийг тус тус үндэслэн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийн даргаар Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга болон “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Ч.Энх-Амгаланг сонгон томилсугай.

2. Удирдах зөвлөлийн даргын ажлыг холбогдох хууль, журамд нийцүүлэн ажиллахыг Ч.Энх-Амгаланд үүрэг болгосугай.

ГИШҮҮД:



**МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ ТӨҮГ
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 02 дугаар сарын
28-ны өдөр

дугаар 02

Улаанбаатар хот

**Удирдах зөвлөлийн нарийн бичгийн
даргыг томилох тухай**

“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.2 дахь заалт, Авлигатай Тэмцэх Газрын 2022 оны “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай” 05/4822 дугаартай албан бичиг, Удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Соёлын яамны Урлаг, уран бүтээлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Кино, дуу дүрсний бодлогын хэрэгжилт хариуцсан шинжээч Гантогоо овогтой Ичинхорлоог 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын ажлыг холбогдох хууль, тогтоомж, журамд нийцүүлэн, Удирдах зөвлөлийн хурлын бэлтгэлийг сайтар хангаж, бичиг баримтыг архив, албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу хөтөлж ажиллахыг Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Ичинхорлоо/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ЭНХ-АМГАЛАН

**МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ ТӨҮГ
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 02 дугаар сарын
28-ны өдөр

дугаар 03

Улаанбаатар хот

**“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын
захирлыг сонгон шалгаруулах тухай**

“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.2 дахь заалт, Удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын сонгон шалгаруулалтыг 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд олон нийтэд нээлттэй зарласугай.

2. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын сонгон шалгаруулалтыг 2 үе шаттай зохион байгуулах ба, эхний үе шатыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан, төвлөсөн хугацаанд танилцуулж, ажиллахыг Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Ичинхорлоо/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ЭНХ-АМГАЛАН

**МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ ТӨҮГ
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 04 дүгээр сарын
11-ний өдөр

дугаар 04

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” А/7 дугаартай тушаалын 2 дахь заалт, Удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэл, 03 тоот тогтоолыг тус тус үндэслэн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын захирлын сонгон шалгаруулалтад оролцохоор Соёлын яаманд ирүүлсэн нэр дэвшигчдийн хүсэлт, танилцуулга болон бусад баримт бичгийн битүүмжлэлийг нээж, захирлын албан тушаалын тодорхойлолтод тавигдсан шаардлага болон сонгон шалгаруулалтын удирдамжид заасан шаардлагын дагуу эхний үе шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шаардлага хангасан нэр дэвшигчдийг удирдах зөвлөлийн ээлжит хуралд танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Сэргэлэн	Соёлын яамны Урлаг, уран бүтээлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Ч.Ундрал	Монголын Үндэсний кино урлагийн зөвлөлийн дарга бөгөөд Ажлын албаны дарга
Гишүүд:	Г.Нямдаваа	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Г.Ичинхорлоо	Соёлын яамны Урлаг, уран бүтээлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Кино, дуу дүрсний бодлогын хэрэгжилтийг хариуцсан шинжээч

2. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын сонгон шалгаруулалтыг 2 үе шаттай зохион байгуулах ба, эхний үе шатыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, товлосон хугацаанд танилцуулж, ажиллахыг нарийн бичгийн дарга /Г.Ичинхорлоо/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ЭНХ-АМГАЛАН

**“МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ” ТӨҮГ-ЫН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Удирдах зөвлөлийн
ажиллах журам батлах тухай

“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.5.7 дахь заалт, “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын Удирдах зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг ханган зохион байгуулж ажиллахыг Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Ичинхорлоо/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн гишүүн Б.Ням-Очирт тус тус даалгасугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЭНХ-АМГАЛАН

**“МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ” ТӨҮГ-ЫН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын захирлын албан тушаалд
Б.Амарсанааг нэр дэвшүүлэх тухай

“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийн ажиллах журмын 2 дугаар зүйлийн 2.11 дэх хэсэг, “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын Удирдах зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын албан тушаалын сонгон шалгаруулалтын 2 дугаар үе шатанд зөвлөлийн гишүүдийн олонхийн санал авч, хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн нэр дэвшигч Д.Амарсанааг шалгаруулсугай.

2. “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын захирлын албан тушаалд нэр дэвшсэн Д.Амарсанаагийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулах албан хүсэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт уламжлах ажлыг зохион байгуулахыг Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Ичинхорлоо)-д үүрэг болгосугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЭНХ-АМГАЛАН

**“МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ” ТӨҮГ-ЫН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Удирдах зөвлөлийн шийдвэрийг
хүчингүй болгох тухай

“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийн ажиллах журмын 2 дугаар зүйлийн 2.11 дэх хэсэг, “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын захиралд нэр дэвшигч Б.Амарсанаагийн 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн өргөдлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн “Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын захирлын албан тушаалд Б.Амарсанааг нэр дэвшүүлэх тухай” 06 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА



Ч.ЭНХ-АМГАЛАН

**“МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ” ТӨҮГ-ЫН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Удирдах зөвлөлийн шийдвэрийг
хүчингүй болгох тухай

“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийн ажиллах журмын 2 дугаар зүйлийн 2.11 дэх хэсэг, “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Удирдах зөвлөлийн шийдвэрийн хүчингүй болгох тухай” 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын сонгон шалгаруулалтыг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд олон нийтэд нээлттэй зарлахаар удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Удирдамжийг Соёлын яам болон бусад байгууллагын албан ёсны вэб хуудсанд байршуулж, дэд ажлын хэсэг байгуулан хэрэгжилтийг хангаж ажиллахыг нарийн бичгийн дарга (Г.Ичинхорлоо)-д даалгасугай.

3. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Удирдах зөвлөлийн гишүүн Б.Ням-очирт үүрэг болгосугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА



Ч.ЭНХ-АМГАЛАН

**“МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ” ТӨҮГ-ЫН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 05 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийн ажиллах журмын 2 дугаар зүйлийн 2.11 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” А/7 дугаартай тушаалын 2 дахь заалт, “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын Удирдах зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн №08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын сонгон шалгаруулалтад оролцогчдын ирүүлсэн баримт бичгийн битүүмжлэлийг нээж, удирдамжид заасан шаардлагын дагуу эхний үе шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шаардлага хангасан нэр дэвшигчдийг удирдах зөвлөлийн ээлжит хуралд танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ч.Ундрал	Удирдах зөвлөлийн гишүүн, Монголын Үндэсний кино урлагийн зөвлөлийн дарга бөгөөд Ажлын албаны дарга
Гишүүд:	Г.Нямдаваа	Удирдах зөвлөлийн гишүүн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Б.Ням-Очир Г.Ичинхорлоо	Удирдах зөвлөлийн гишүүн, Найруулагч, продюсер Соёлын яамны Урлаг, уран бүтээлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Кино, дуу дүрсний бодлогын хэрэгжилтийг хариуцсан шинжээч

2. Сонгон шалгаруулалтын нэгдүгээр үе шатны үйл ажиллагааг шуурхай зохион байгуулан санал дүгнэлийг удирдамжид заасан хугацаанд танилцуулж, ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /Ч.Ундрал/-д үүрэг болгосугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА



Ч.ЭНХ-АМГАЛАН

**“МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ” ТӨҮГ-ЫН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 05 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай

“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийн ажиллах журмын 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 11 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 3.8, 3.9, 3.10, 3.1 дахь хэсгийг тус тус үндэслэн “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын Удирдах зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Захирлын үүргийг гүйцэтгэх төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч В.Дарханбаатартай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг **“Сайн”** гэж дүгнэсүгэй.

2. Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлтийн дүгнэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэхийг Захирлын үүргийг гүйцэтгэх төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч В.Дарханбаатарт даалгасугай.

ДАРГА



Ч.ЭНХ-АМГАЛАН

**“МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ” ТӨҮГ-ЫН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 05 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот


“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын захирлын албан тушаалд
Б.Түмэн-Өлзийг нэр дэвшүүлэх тухай

“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийн ажиллах журмын 2 дугаар зүйлийн 2.11 дэх хэсэг, “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын Удирдах зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын албан тушаалын сонгон шалгаруулалтын 2 дугаар үе шатанд зөвлөлийн гишүүдийн олонхийн санал авч, хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн нэр дэвшигч Б.Түмэн-Өлзийг шалгаруулсугай.

2. “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын захирлын албан тушаалд нэр дэвшсэн Б.Түмэн-Өлзийгийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулах албан хүсэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт уламжлах ажлыг зохион байгуулахыг Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Ичинхорлоо)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ЭНХ-АМГАЛАН

**“МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ” ТӨҮГ-ЫН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 11 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 12

Улаанбаатар
хот

“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг дэмжих тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ - ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшинг 1 дүгээр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Үйлдвэрийн газрын 2023 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэн төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр авлагыг барагдуулах, худалдан авалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг захирал (Б.Түмэн-Өлзий)-д даалгасугай.
3. Энэхүү тогтоололын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Ичинхорлоо)-д даалгасугай.



**“МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ” ТӨҮГ-ЫН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 11 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 13

Улаанбаатар
хот


Хариуцлагын гэрээ байгуулах тухай


Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6 дахь хэсэг, Кино урлагийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Соёл, урлагийн салбарын хууль, тогтоомж, төрөөс кино урлагийн талаар авч хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг салбарын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ – ийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр үйлдвэрийн газрын захиралтай 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Удирдах зөвлөлтэй жилийн хугацаатай “Хариуцлагын гэрээ” байгуулж ажиллуулсугай.

2. Гэрээний хавсралтаар “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-аас салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 2024 онд хийж гүйцэтгэх зорилт, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж ажиллахыг “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын захирал (Б.Түмэн-Өлзий)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Ичинхорлоо)-д даалгасугай.


Ч.ЭНХ-АМГАЛАН



**“МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ” ТӨҮГ-ЫН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 11 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 14

Улаанбаатар
хот

Удирдах зөвлөлийн зардал,
гишүүдийн урамшууллыг батлах тухай

Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны аравдугаар сарын 13-ны 12 дугаар тогтоол, “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.5.3 дахь заалт, “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ийн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардал, зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн даргын урамшууллыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй дүйцүүлэн улиралд нэг, жилд нийт дөрвөн удаа 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгосугай.
2. Зөвлөлийн гишүүдийн урамшуулалд шаардагдах зардлыг үйлдвэрийн газрын 2024 оны зорилтот түвшинд тусгагдсан удирдах зөвлөлийн зардалд багтаан олгохыг “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын захирал (Б.Түмэн-Өлзий)-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Ичинхорлоо)-д даалгасугай.

Ч.ЭНХ-АМГАЛАН